



ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2019 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТАСГИЙН ДАРГА,

АХЛАХ БҮРТГЭГЧ

Ө.ГАНЗОРИГ

ХЯНАСАН:

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН

ХЭЛТСИЙН ДАРГА

Д.МӨНХБОЛД

2019-12-15



1. БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант хугацаанд Орхон аймгийн 2 сум, 26 багийн нийт 105000 иргэнд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон,

Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу иргэний, эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг орон нутагт эрхлэн зохион ажиллаж байна.

Тус хэлтэс нь Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа иргэдэд дараах 4 цэгээс хүргэж байна. Үүнд:

- ❖ Оюут багт байрлах Захиргааны II байр /УБХ байрлаж буй байр/
- ❖ Аймгийн ЗДТГ-ын “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”
- ❖ Гэр хорооллын эцэст байрлах “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”
- ❖ Жаргалант сумын ЗДТГ

2019 оны үйл ажиллагаагаа Монгол Улсын Их Хурлаар батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Монгол улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Нэг иргэн-Нэг бүртгэл” үндэсний хөтөлбөрийг иргэдэд сурталчлах, албан хаагчидад хуулийг зөв хэрэглэх талаар сургалт зохион байгуулах, иргэд, үйлчлүүлэгчдийг ая тухтай үйлчлүүлэх нөхцлөөр хангахад голлон анхаарч ажиллаа.

1.2. Хүний нөөцийн талаар

2019 онд хэлтэс нь төрийн захиргааны 19, төрийн үйлчилгээний албан хаагч 5, гэрээт албан хаагч 4 нийт 28 албан хаагчтайгаар УБЕГ-ын даргын тушаалаар баталсан бүтэц, орон тоогоор ажиллаж байна.





Мэдүүлэг гаргах албан хаагчид оролцон ХАСХОМ-ээ хуулийн хугацаанд гарган холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэн ажилласан.

Тайлангийн хугацаанд УБЕГ-ын даргын 2019 оны Б/224 дугаар тушаалаар Н.Түвшинжаргал Улсын бүртгэгчээр томилогдсон.

Байгууллагын ёс зүйн хорооны хурлаар архивч Д.Алтан-Одыг авч хэлэлцэн цалинг 1 сарын хугацаатай 20 хувиар хасах арга хэмжээ авагдсан.

Мөн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 2019 оны 05 дугаар сарын 13-17 ны өдрүүдэд УБЕГ, Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулсан сургалтад хамрагдан БНСУ-д туршлага судлах аялалд оролцсон.

1.1 Албан хаагчдын сургалтын талаар

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 2019.02 сарын 21-22 ны өдрүүдэд УБЕГ-аас зохион байгуулсан Удирдах ажилтны зөвлөгөөнд оролцсон.

Монгол Улсын Засгийн Газрын 2011оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам” -д заасны дагуу гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтыг 2019 оны 3 дугаар сар 29-ний Пүрэв гаригийн 16⁰⁰ цагт зохион байгуулсан бөгөөд хэлтсийн ажилтан албан хаагчид дуут дохиогоор гарч сургуулилтанд идэвхитэй оролцлоо.



2019.03.29 нд УБЕГ-аас ирүүлсэн 2019.03.13 ны өдрийн 3/2022 албан тоотоор ирүүлсэн чиглэлийн дагуу Орхон аймгийн Прокурорын газраас авлигын эсрэг гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжуудын талаар нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

2019.05.01 нд Орхон аймгийн ЗДТГ, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академаас хамтран зохион байгуулсан Орхон аймгийн Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд нийт албан хаагчид хамрагдсан.



2019.05.06 нд “Сэтгэлийн анир” төслийн нээлт болсон бөгөөд тус төслийн хүрээнд харилцаа, хандлага, гэр бүлийн хөгжлийн талаар нийт 4 удаагийн сургалт зохион байгуулагдаж албан хаагчдаас сэтгэлзүйн судалгаа авагдсан.



2019.05.09 нд Орхон аймгийн Статистикийн хэлтэстэй хамтран Гамшгаас хамгаалах “Иргэний бүртгэл мэдээлэл, статистик судалгааны” мэргэжлийн анги байгуулан гамшгийн бэлэн байдлын улсын үзлэг, дадлага, сургуулилтад амжилттай оролцсон.



2019.05.27 нд Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан “Хүний эрх ба, жендер” сургалтад хэлтсийн дарга хамрагдсан.

2019.05.30-31 ний өдрүүдэд УБЕГ-аас зохион байгуулсан Иргэний улсын ахлах бүртгэгч, сумдын бүртгэгч, бичиг хэргийн ажилтны хамтарсан “Төслийн дунд хугацааны үр дүн” сургалтад 4 албан хаагч хамрагдсан.

2019.06.04 ний өдөр Орхон аймгийн ЗДТГ, Удирдлагын академтай хамтран зохион байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөлт” сэдэвт сургалтад 5 албан хаагч хамрагдсан.

2019.06.10 ны өдөр Орхон аймгийн ЗДТГ, Монгол улсын Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулсан Төрийн албаны шинэ хууль, төрийн албаны шинэтгэлийн талаар ТЗ-ийн нийт албан хаагчид хамрагдсан.

2019.06.21 нд Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас зохион байгуулсан “Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлууд” сэдэвт сургалтад Хэлтсийн дарга, ахлах бүртгэгч нар хамрагдсан.

3. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

3.Эд хөрөнгө амчлөх, эзэмших, ашиглах, эрхийг бүртгэж баталгаажуулах талаар

2019 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн EPRS програмын шинэчилсэн хувилбарыг бүртгэлийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн иргэн, хуулийн этгээдээс 18427 мэдүүлэг, нотлох баримтыг хүлээн авч улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:

Анхны бүртгэл -1524

Өмчлөх эрх шилжүүлэх-3137

Барьцааны гэрээ-12581


Бүртгэлд өөрчлөлт оруулах-662

Бусад-3

Лавлагаа, хуулбар -461

Урьдчилсан тэмдэглэл-59

Үйлчилгээний төрөл хувиар



4. ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

4.1 Иргэний үнэмлэх олголтын талаар

Тайлангийн хугацаанд нийт 6047 иргэнд иргэний үнэмлэх олголоо. Нийт иргэний үнэмлэхний 1269 нь 16 нас хүрч анх удаа иргэний үнэмлэх авч буй иргэд байна.

Мөн иргэний үнэмлэхний хугацаа дууссан иргэдийн 25 насны сунгалт 1403, 45 насны сунгалт 1232, хаяж үрэгдүүлсэн болон бусад шалтгаанаар 2143 нийт 6047 иргэний үнэмлэх олголоо.

4.2 Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн талаар

Тайлангийн хугацаанд иргэний гэр бүлийн байдлын

№	Үзүүлэлт		Тоо
1	16 нас хүрч шинээр олгогдсон үнэмлэх		1267
2	Дахин олгосон үнэмлэх	Хаяж үрэгдүүлсэн	1955
		Хүчинтэй байдлаа алдсан	58
		Буруу бичигдсэн	0
		Овог нэр өөрчилсөн	14
		Төрсөн он тогтоосон	10
		Хаягийн хөдөлгөөн	106
3	Хугацаа дуусч солиулсан	25 нас хүрч	1403
		45 нас хүрч	1232
	Нийт		6047

бүртгэлийн чиглэлээр нийт 3641 бүртгэл хийгдсэнээс 2164 төрөлт, 584 гэрлэлт, 158 гэрлэлт дуусгавар болсон, 3 гэрлэлт сэргээлт, 64 хүүхэд үрчлэлт, 85 овог, эцгийн нэр,

нэр өөрчилсний бүртгэл, 70 эцэг тогтоосны бүртгэл, 513 нас барсны бүртгэл хийн сар бүрийн мэдээ, тайлан, ИУБ маягтуудыг УБЕГ-т хугацаанд нь хүргүүлэн ажиллаа.



4.3 Үндэсний энгийн гадаад паспорт олголтын талаар

2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 3113 иргэнээс гадаад паспортын материал бүрдүүлэн авч, Орхон аймгийн Тагнуулын газрын шуудангаар явуулж иргэдэд түргэн шуурхай олгох ажлыг зохион байгуулж ирлээ.

4.4 Иргэн шилжин суурьших хөдөлгөөний талаар

2019 оны жилийн эцсийн байдлаар гадны аймаг хотоос Орхон аймагт шилжин ирсэн 1598 иргэнийг /999 насанд хүрсэн, 599 нь 16-аас доош насны хүүхэд/ бүртгэж, аймаг дотроо баг хооронд болон сум хооронд шилжсэн 3850 иргэнийг зохих журмын дагуу бүртгэлээ.

5.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

5.1 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаар

2019 оны жилийн эцсийн байдлаар хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр шинээр бүртгэгдсэн хуулийн этгээд -256 /ХХК-193, хоршоо-1, салбар-2, сан-1, ТББ-49, ҮЭ-4, УТҮГ-6/, 320 иргэнд оноосон нэрийн баталгаажуулалт, Хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн бүртгэл-343, шилжин явсан-4, татан буугдсан-41 аж ахуйн нэгж, 124 хуулийн этгээдийн тамга, тэмдгийг хураан авч, 344 иргэн, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын дугаар олгосон байна.Тайлангийн хугацаанд 1432 бүртгэлийн үйлчилгээг хуулийн этгээдийн

улсын бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хугацаанд үзүүлсэн.

5.2 Бусад ажлын талаар

Хуулийн этгээдийн бүртгэлийн архивыг цахимжуулах ажлын хүрээнд 2018 оны 11 сарын 01 нээс 2019 оны 03 дугаар сарын 01 ний дотор 4650 хуулийн этгээдийн хувийн хэргийг бүрэн цахимжуулан дуусгалаа.

Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Шашин сүм хийдийн асуудал хариуцсан зөвлөлтэй хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллага, сүм хийдийн үйл ажиллагаанд “Төр, сүм, хийдийн харилцааны тухай хууль”, “Аймгийн нутаг дэвсгэрт сүм хийд, шашны байгууллаг байгуулж, үйл ажиллагаа явуулах журам” болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд 2019 оны 03 сарын 09-10 өдрүүдэд шалгалт зохион байгууллаа. Тус шалгалтад Орхон аймагт үйл ажиллагаа эрхэлж буй Христийн 20 сүм, шашны байгууллага хамрагдан 2 зөрчил илрүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаа.

6 . АЛБАН БИЧГИЙН ЭРГЭЛТ, ТУШААЛ, ШИЙДВЭР, ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТАЛААР

6.1. Албан бичгийн эргэлтийн талаар

Тайлангийн хугацаанд тус хэлтэс нийт 1927 албан бичиг хүлээн авснаас хариутай 1009 бичгийн хариуг хүргүүлэн ажилласан.

Ирсэн албан бичгүүдийг ангилан авч үзвэл:

-Цагдаагийн байгууллагаас 683 албан бичиг хүлээн авч 629 хариутай бичигт албан бичгээр болон архивын лавлагаагаар хариу хүргүүлсэн.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 241 албан бичиг хүлээн авч 121 хариутай бичигт албан бичгээр болон архивын лавлагаагаар хариу хүргүүлсэн.

-Шүүхийн байгууллагаас 182 албан бичиг хүлээн авч 88 хариутай бичигт хариуг албан бичгээр

-УБЕГ-аас 151 албан бичиг ирснийг ангилан авч үзвэл тушаал 16, үүрэг, даалгавар, чиглэл 18, журам 9, онлайн сургалт 8 тус тус ирсэн байна.

-Аймгийн ЗДТГ-аас 50 албан бичиг ирсэн байна.

-Бусад байгууллагаас 107 албан бичиг хүлээн авч 63 хариутай бичигт албан бичгээр болон архивын лавлагаагаар хариу хүргүүлсэн.

6.2. Тушаал шийдвэр, хурлын тэмдэглэлийн талаар

Тайлангийн хугацаанд хэлтсийн даргын А тушаал 14, Б тушаал 16 гарч даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл 11, хамт олны хурлын тэмдэглэл 2, хэлтсийн шуурхайн тэмдэглэл 30 хөтлөгдсөн болно.

6.3. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн талаар

Тайлангийн хугацаанд иргэдээс нийт 15 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаа. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг ангилан авч үзвэл:

1. Өргөдөл, гомдлын ангилал			
Хүсэлт	Гомдол	Талархал	Санал
13	1	0	1
2. Өргөдөл, гомдол хүлээн авсан хэлбэр			
Бичгээр	Утсаар		Цахимаар
9	4		2
3. Өргөдөл гомдлын агуулга			
Иргэний бүртгэлийн чиглэлээр	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр	Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр	Бусад
11	1	0	3

7. ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЛААР

2019 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр 3662 бүртгэлд хянан 11 зөрчил, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 6279 бүртгэл хянан 170 зөрчил, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 145 бүртгэл хянан 11 зөрчил тус тус илрүүлэн зөрчлийг арилган ажилласан.

Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан зөрчил үйлдсэн 571 иргэн, 2 хуулийн этгээдэд хариуцлага тооцон нийт 13.860.000 төгрөгийн торгууль ногдуулан Орхон аймгийн хариуцсан хяналтын прокурорт хяналуулсан.

Хяналтын улсын байцаагчийн 58 дүгнэлт үйлдэн Хяналт, шалгалтын газраар баталгаажуулсан.

8. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

8.1 Иргэд байгууллагыг сурталчилгаанд хамруулсан байдлын талаар

Иргэд байгууллагад хүргэсэн сурталчилгааны хүрээнд:


2019.03.29 нд Баянцагаан багт нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж иргэдэд Улсын бүртгэлийн хууль тогтоомжуудын талаар сурталчилсан.



2019.04.08 нд Жаргалант сумын иргэдэд Улсын бүртгэлийн хууль тогтоомжуудын талаар сурталчилсан.



2019.04.09 нд Эрх зүйн хөтөч нарт Улсын бүртгэлийн хууль тогтоомжуудын талаар сурталчилсан.



2019.05.01 нь Хуульчдын Про Боно өдөрлөгийн хүрээнд “Амарын талбайд зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр”-лөгт ороцсон.



2019.05.24 нд Аймгийн ИТХ-ын ажлын албатай хамтран Уртынгол багт зохион байгуулагдсан “Төлөөлөгчийн нэг өдөр” өдөрлөгт оролцон тус багийн иргэдийг бүртгэлийн үйлчилгээ, зөвлөгөө, мэдээлэл, гарын авлагаар хангасан.

2019.06.28 нд Говил багт зохион байгуулагдсан "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийн үеэр Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон 2018 оны хяналт шинжилгээ үнэлгээгээр тэргүүн байрт шалгарсан шагналын мөнгөнөөс тус багийн өрх толгойлсон зорилтот бүлгийн 1 өрхөд хүнсний болон хүүхдийн хичээлийн хэрэгсэл, хувцас, мөнгөн тусламж зэргийг бэлэглэн сайн үйлсийн аянд нэгдлээ.



2019.08.07 нд Баянбулаг багт нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж иргэдэд Улсын бүртгэлийн хууль тогтоомжуудын талаар сурталчилсан.



2019.09.06 нд Малчин багт нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж иргэдэд Улсын бүртгэлийн хууль тогтоомжуудын талаар сурталчилсан.




2019.10.19, 2019.10.26 ны өдрүүдэд УБЕГ-ын даргын 2019.10.15 ны А/1043 тушаал, төлөвлөгөөний дагуу “Нээлттэй хаалга”-ны өдөр зохион байгуулсан.



8.2 Байгууллагын үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн байгууллагын стандартад тусгах саналын дагуу тус хэлтсийн 17 албан хаагчаас нийт 39 /давхардсан тоогоор/ санал гарсныг нэгтгэн 10 санал болгон хүргүүлсэн.

Мөн Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс байрлаж буй Захиргааны II байранд иргэдэд мэдээлэл өгөх 2 ширхэг “Ухаалаг дэлгэц” байршуулан улсын бүртгэлийн үйлчилгээний талаархи дэлгэрэнгүй мэдээллийг тус дэлгэцээс иргэд авах боломжийг бүрдүүллээ.



Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс үйлчилгээний танхимдаа 2017 оноос хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх цонх гаргасан бөгөөд тус хэлтэс байрлаж буй Захиргааны II байрны гадна тэргэнцэртэй иргэн орж гарах зориулалтын шат хийсэн.

Хэлтсийн иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн тус бүр 1 улсын бүртгэгчийг дохионы хэлний сертификат олгох сургалтад хамруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлэх цонхонд томруулдаг шил, сонсголын аппарат байршуулан иргэдэд үйлчилж байна.

Үйлчилгээний танхимд үйлчилгээ үзүүлж буй улсын бүртгэгч нар Байгууллагын үйлчилгээний стандартын 7.1.2-т заасны дагуу “Үйлчилгээний ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн, өндөр настан /70-аас дээш/ иргэдэд дараалал харгалзахгүй үйлчилж болно” гэж заасны дагуу үйлчилгээ үзүүлж байна.




9. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ТАЛААР

Хэлтсийн сервер вакуум хаалт бүхий өрөөнд байрлаж, журамд заасан тавигдах шаардлагуудыг бүрэн хангасан. Албан хаагчдын мэдээллийн санд нэвтрэх эрхийг тухай бүрт нь нээх болон хаах талаар албан тоот хүргүүлэн ажиллаж байна.

Хэлтсийн дарга мэдээллийн сантай ажилладаг нийт албан хаагчдаас нууцын баталгааг дахин гаргуулан авсан бөгөөд аюулгүй ажиллагааны талаар хяналтын улсын байцаагч, мэдээлэл технологийн ажилтан цаг тухайд нь зааварчилгаа өгч ажиллаж

байна. Шинээр нэвтэрч буй програм болон програмын шинэчлэлийг цаг тухай бүрт нь албан хаагчдын компьютерт суулган, албан хаагчдад тухай бүрт нь зааварчилгаа өгч байна.



Хэлтсийн үйлчилгээний танхим болон ажлын өрөөг орой бүр лацадсан тэмдэглэлийг бүх албан хаагчид хөтлөн, хяналтын байцаагч өдөр бүр хяналт тавин ажиллаж байна.



10.1 Батлагдсан төсвийн хүрээнд хэлтсийн мөнгөн хөрөнгө үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулна.


Тайлант онд тус хэлтэст үндсэн үйл ажиллагааны санхүүжилт 361,5 сая.төгрөг, нэмэлт санхүүжилтийн 24,1 сая.төгрөг, нийт 385,6 төгрөгийн төсвийн зарцуулалтын эрх нээгдсэн. Батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, зардлын бүлэг зүйлийн дагуу хугацаанд нь зарцуулан ажиллаж байна.

Мөн 2020 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 36,6 сая /техник, тоног төхөөрөмж 11,6 сая, гэрээт ажилтан 25,0 сая/ төгрөгийн санхүүжилт авахаар аймгийн Засаг даргаар шийдвэрлүүлсэн.

10.2 2019 оны үнэт цаас, маягтыг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулж, өмч хөрөнгийн тооллого хийнэ.

[illegible]

Өнгөрсөн онтой харьцуулахад хүчингүй болсон болсон үнэт цаасны тоо 27,3 хувиар буурсан байна.



2019 ийг аяархад үргэлжлэн өргөснийг өргөснийг аяархад 2019 ийг 12 аяархад нэгдсэн 23-27-ийг өргөснийг аяархад өргөснийг аяархад аяархад.

10.3 Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирлын санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамт хуульд заасан хугацаанд ерөнхий газарт хүргүүлнэ.

УБЕГ-ын Санхүүгийн хэлтэст дараах нэр төрлийн мэдээ, тайланг “Төсвийн тухай хууль”-д заасан хугацаанд нь сар, улирал бүр цахим шуудангаар болон шаардлагатай тохиолдолд эх хувиар нь хүргүүлэн ажиллаж байна. Мэдээ, тайланг хүргүүлсэн хугацааг дараах хүснэгтээр харуулав.

№	Мэдээ, тайлангийн төрөл	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар
1	Төсвийн гүйцэтгэлийн мэдээ / багц /	2.02	3.01	4.02	5.01	6.05	7.02	8.01	9.03	10.01	11.01	12.03
2	Цахим үнэмлэхний тайлан	2.05	3.05	4.02	5.01	6.06	6.29	8.01	9.03	10.01	11.01	12.03
3	Үйлчилгээний орлогын мэдээ	2.05	3.06	4.04	5.01	5.31	6.29	8.03	9.06	9.27	10.30	11.30
4	Үнэт цаасны тайлан	1.31	3.02	3.31	4.27	6.05	7.02	7.30	8.30	10.06	11.05	12.04

10.4 2020 оны төсвийн төслийг боловсруулж, хуульд заасан хугацаанд нь ерөнхий газарт хүргүүлнэ.


Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1-д заасны дагуу тус хэлтсийн 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөллийг 2019

оны 06 дугаар сарын 17-ны өдөр хуулийн хугацаанд нь албан бичгээр УБЕГ-т хүргүүлсэн болно.

10.5 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2019 оны эхний 11 сарын байдлаар Төсөв, гүйцэтгэлийн 42, хөрөнгө оруулалт, тендэр, худалдан авалттай холбоотой 36, бусад 59, нийт 137 төрлийн мэдээлэл байршуулахаас бүх мэдээллийг 100% хуулийн хугацаанд нь <http://www.shilendans.gov.mn/org/7553> цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбараар тус тус мэдээллэн ажиллаж байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг УБЕГ-ын ХШҮДАГ болон Аймгийн Төрийн Аудитын тус тус хянан шалгасан бөгөөд тухай бүр 100 хувь дүгнэгдсэн болно.



10.6 Хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд аудитын байгууллагаар аудит хийлгэж, зөрчил бага илэрсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Аймгийн Төрийн аудитын газарт хүргүүлсэн бөгөөд ТӨАГазрын даргын тушаалаар 2018 оны санхүүгийн тайланд аудит хийлгүй “ИТГЭЛ” үзүүлсэн болно.



10.7 Төсөв, зардлыг бууруулах чиглэлээр тодорхой ажил санаачлан зохион байгуулна.

Төсөв, зардлыг бууруулах чиглэлээр дараах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд :

1. Ажлын цагийн ашиглалтанд хяналт тавин ажлын цагийг хурууны хээгээр бүртгэн, хоцорсон минут цагаар цалингаас хасч тооцсоноор тайлант онд 609,326 төгрөг хэмнэсэн нь 2018 оны мөн үеэс 55,38 хувиар буурсан байна.
2. 2019 оны төсөвт Цалингийн зардлын төсөвт УБЕГ-н Санхүү, төлөвлөлтийн газарт хандан тооцоо судалгаагаа хүргүүлэн 2 удаагийн тодотгол оруулан 18,4 сая төгрөгийн төсөв шийдвэрлүүлсэн. 2019 оны 11 дүгээр сард 905,0 мянган төгрөгийн дотоод албан томилолтын өглөг үүссэнийг мөн УБЕГ-т хандан барагдуулсан болно.

11. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР

2019.03.14 нд Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс байрлаж буй Захиргааны II байранд байрлах төрийн байгууллагуудын албан хаагчдын дунд тус хэлтсийн санаачлагаар “Гар бөмбөг”-ийн тэмцээн зохион байгуулсан.



2019.04.04 нд Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон Сургалтын төвийн уулзвараас “Номин” агуулах хүртэлх замын дагуух газрын хогийг цэвэрлэсэн.



Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу Аймгийн хэмжээнд 2018.05.10-ны өдөр бүх нийтийн мод тарих үндэсний өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон Сархиа ууланд шинэс мод тарив.



2018.05.28-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Хамт олны зүгээс нийт ажилтан, албан хаагчдынхаа бяцхан үрсийг хүлээн авч гарын бэлэг гардууллаа.



2019.10.12 өдөр Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу намрын бүх нийтээр мод тарих өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон Бүрэнбүст уулын энгэр “Ёс заншлын өргөө”-ний орчимд 10 ширхэг чацарганы суулгац тарьлаа.



Байгууллагын орчны 50 метр газрын цас мөс болон шарилжийг тогтмол цэвэрлэн устгаж байна.





2019 оны 11 сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад Орхон аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 18-н албан хаагч хамрагдлаа.



Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 79 жил нэгдсэн тогтолцоонд шилжсэний 10 жилийн ойн хүрээнд Орхон аймгийн Баян-Өндөр сумын албан хаагчид болон 22 багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтнуудын дунд “АХА” тэмцээн зохион байгууллаа.



2019 оны 11 сарын 26-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 17дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа "МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ" Орхон аймагт амжилттай зохион байгуулагдлаа.



“БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ – ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ” сарын аяны хүрээнд 2019 оны 11 сарын 30-ны өдөр тус байгууллагын албан хаагчдын дунд “Төрийн албан хаагчийн ёс зүй, бүртгэлийн хууль тогтоомж, үйлчилгээний стандарт”-ын талаар жүжигчилсэн үзүүлбэр болон АХА тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.



2019 оны 12 сарын 02-ны өдөр Орхон аймгийн тойргийн нотариатуудад Улсын бүртгэлийн шинэчилсэн багц хуулиуд түүнийг дагаж гарсан журмууд, цахим

үйлчилгээ (ebarimt, burtgel.mn) сэдвээр сургалт, ажил хэргийн уулзалт ярилцлага зохион байгууллаа.



“ОЙЛГОЁ, ХҮНДЭЛЬЕ -ГЭР БҮЛИЙНХЭЭ ТӨЛӨӨ “ уриатай аяны хүрээнд Орхон аймгийн цагдаагийн газраас Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэн ахмад Д.Ганбат, дэслэгч Н.Мөнхболор нарыг урьж албан хаагчдад “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, гомдол мэдээллийг хэрхэн гаргах, хүлээж авах” сэдвээр сургалт зохион байгууллаа.





2019.10.10 нд Онцгой байдлын газраас гал түймэр болон болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх талаархи сургалтад нийт албан хаагчид хамрагдсан.



Мөн 7 хоног бүрийн Пүрэв гаригийн өглөөний 08.00-09.00 цагийн хооронд албан хаагчид дотооддоо сургалт зохион байгуулан хэвшсэн бөгөөд 2019.09.26 ны Пүрэв гаригт хэлтсийн нэгтлан бодогч албан хаагчдын цалин хөлс, урамшуулал, нийгмийн даатгалын талаар, 2019.10.03 ны өдөр Улсын ахлах

бүртгэгчид Улсын бүртгэлийн багц хууль болон холбогдон гарсан журмуудын талаар, 2019.12.05 ны Пүрэв гаригт мэдээлэл технологийн ажилтан ebarimt аппликейшныг ашиглаж хэрхэн улсын бүртгэлийн үйлчилгээг авах, мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын төлбөр шалгах системд нэвтэрч төлбөрийг шалгах, баталгаажуулах болон тайлан мэдээ гаргах талаар сургалт зохион байгууллаа.

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2019 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлаа бүрэн хийж гүйцэтгэлээ.

2017, 2018 онуудад Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр тэргүүлсэн амжилтаа бататгах зорилтоо хэрэгжүүлэн ажиллалаа.

2020 онд тус хэлтэс нь дараах ажил, арга хэмжээг зорилго болгон ажлах тал дээр анхааран ажиллах болно.

1. Улсын бүртгэлийн хууль, тэдгээрийг даган гарсан хууль, тогтоомжуудыг чанд мөрдөн ажиллах, сурталчлах
2. 2020 оны УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиудыг амжилттай зохион байгуулах
3. Монгол улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Нэг иргэн-Нэг бүртгэл” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарах
4. Төрийн албаны тухай хууль, түүнийг дагалдан гарсан журмуудыг хэрэгжүүлэн ажиллах
5. Бүртгэлийн үйлчилгээний стандарт болон төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлыг анхаарах, олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулах
6. Хэлтсийн хэмжээнд авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар албан хаагчдын дунд тодорхой ажил зохион байгуулах
7. Үйлчлүүлэгч, харилцагчид үйлчилгээ авахад ая тухайтай байх орчин нөхцөл, чирэгдэлгүй шуурхай үйлчилгээ үзүүлэх тал дээр ажил зохион байгуулах
8. Албан хаагчдын эрх зүйн мэдлэг болон ажлын ур чадварыг дээшлүүлэх талаар сургалтын болон бусад арга хэмжээнүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх
9. Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр анхаарлаа чиглүүлэн ажиллах болно.

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС